



**ДОРНОГОВЬ АЙМАГ
ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/108

Амна-Ус

Г Газар эзэмшүүлэх төсөл сонгон Г
шалгарууралт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам", сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 09/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулсугай.
2. Төсөл сонгон шалгаруулах зарчмаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зохион байгуулах хугацааг хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Газрын даамал (М.Ууган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Хишиг-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.НАРАНМӨНХ

Сумын Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 12-ны өдрийн
А/109 дугаар захирамжийн хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЧМААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

| Д/д | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Байршил | Зориулалт | Талбайн хэмжээ (га) | Хугацаа /жил/ | Зохион байгуулах хугацаа |
|-----|-----------------------------------|-------------------------------|--|---------------------|---------------|--------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | 5112460 | 3 дугаар багийн нутаг дэвсгэр | 3413: Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж | 71993039 | 15 | 2026.06.15 |
| 2 | 5112461 | 3 дугаар багийн нутаг дэвсгэр | 3413: Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж | 285943894 | 15 | 2026.06.15 |
| 3 | 5112462 | 3 дугаар багийн нутаг дэвсгэр | 3413: Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж | 4623101 | 15 | 2026.06.15 |
| 4 | 5112464 | 3 дугаар багийн нутаг дэвсгэр | 3413: Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж | 27009651 | 15 | 2026.06.15 |
| 5 | 5112465 | 3 дугаар багийн нутаг дэвсгэр | 3413: Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж | 209600 | 15 | 2026.06.15 |
| 6 | 5112466 | 3 дугаар багийн нутаг дэвсгэр | 3413: Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж | 331655595 | 15 | 2026.06.15 |